



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ  
ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

2024 оны 04 сарын 19 өдөр

Дугаар 5/2024

Улаанбаатар хот

Б.Энхжаргалд сахилгын шийтгэл  
ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1, 27 дугаар зүйлийн 27.4.3 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1 дэх хэсэг, 40 дүгээр зүйлийн 40.1 дэх хэсэг Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1.2, 48.4 дэх хэсэг, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 10.4, 10.8 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Бямбын Энхжаргал хууль, тогтоомж болон албан тушаалын тодорхойлолтод заасан үүргээ биелүүлээгүй нь Хяналт шалгалтын газрын 2024 оны 1497 дугаартай хяналтын улсын ахлах байцаагчийн дүгнэлт, өөрийн гаргасан тайлбар болон холбогдох нотлох баримтаар тогтоогдсон тул түүнд 2024 оны 04 дүгээр сарын 19-ний өдрөөс эхлэн нийт ажилтанд зарлах хэлбэрээр нээлттэй сануулах сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомжийг мөрдөж, үүрэгт ажилдаа хариуцлагатай хандахыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн Хуулийн этгээд, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тасгийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч Б.Энхжаргалд үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг чанд сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар /Г.Анхныбаяр/, Нийслэлийн Хан-Уул дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс /С.Оюун-Эрдэнэ/-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Г.Цолмон/-т үүрэг болгосугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГА



Д.ДЭЛГЭРСАЙХАН

142401190